



ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

ХӨРВӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА
5 ДУГААР САР

- » Судалгааны хураангуй
- » I ангиллын хувьцааны хөрвөх чадвар
- » I ангиллын хувьцааны арилжааны дүн
- » Шинжээчийн дүгнэлт

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ:

- 2023 оны эхний 5 сарын байдлаар жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны 7.26% нь арилжаалагдсан байна.
- I ангиллын хувьцааны өдрийн дундаж арилжааны дүн 46.2 сая төгрөгт хүрч 2022 оны 12 сараас 56.6% өссөн үзүүлэлттэй гарлаа.
- Үүнд хамгийн их нөлөө үзүүлсэн нь Хаан банк болон худалдаа хөгжлийн банкны IPO ба I ангиллын компаниудын 5-р сарын өдрийн дундаж арилжаа 2023 оны 4-р сараас 55.7% дахин өслөө.


Чөлөөт хөрвөх хувьцаа буюу Free float гэдэг нь Компанийн нийт гаргасан хувьцааны 5%-аас бага хувийг эзэмшдэг жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаар хэмжигддэг.

I АНГИЛЛЫН ХУВЬЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР 2023М5

Энэхүү судалгаагаар Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 26 хувьцаат компанийн хөрвөх чадварыг илтгэдэг үзүүлэлт болох чөлөөт хөрвөх хувьцаанд эзлэх арилжигдсан хувьцааны ширхгийн дүнг авч үзлээ. 2023 оны эхний 5 сарын байдлаар нийт I ангиллын компаниудын арилжигдсан ширхгийн чөлөөт хөрвөх хувьцаанд эзлэх хувь дунджаар 7.26% байна. Талх чихэр, Монголын хөрөнгийн бирж, Богд банк, Ард Кредит ББСБ болон Инвекстор ББСБ дунджаас өндөр буюу чөлөөт хөрвөх хувьцааны арилжаалагдаж буй идэвх сайтай байна. **2-р сард Талх чихэр ХК-н 5%-аас их хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо 8.49% буюу 66,807 нэгжээр өсч чөлөөт хөрвөх хувьцааны тоог 169,832 болгон буурууллаа. Мөн 3-р сард Ард санхүүгийн нэгдлийн 5%-аас их хувьцаа эзэмшигчийн тоо 1-ээр буурснаар чөлөөт хөрвөх хувьцааны тоо 9.97%-аар өсч 16,600,212 ширхэг болсноос гадна Богд банкны хувьцаа 20 хуваагдсан нь арилжааны идэвхийг нэмэгдүүлсэн юм.**

МХБ-ИЙН I АНГИЛЛЫН 26 ХУВЬЦААТ КОМПАНИ, 2023.01.01-2023.05.31

Чөлөөт хөрвөх хувьцаа ба нийт арилжигдсан ширхэг, сая ширхгээр




I АНГИЛЛЫН ХУВЬЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР 2007-2023М5

2023 оны 5 сарын байдлаар чөлөөт хөрвөх хувьцаанд эзлэх арилжигдсан хувьцааны ширхгийн хэмжээ өмнөх 16 жилийн дунджаас 3% бага гарсан байна.

Өнгөрсөн онуудад арилжааны идэвх хэр байсныг харвал, 2007-2022 оны хоорондох чөлөөт хөрвөх хувьцаа дахь арилжигдсан ширхгийн дүн 2-27%-ийн хооронд байна. Энэ үзүүлэлт нь 2007 оноос хойш өссөн трендтэй буюу хөрвөх чадвар нэмэгдсэн харагдаж байна. 2007, 2008 болон 2009 оны зах зээлийн хямралын үеэр бууралт үзүүлсэн бол 2010 оноос өсөж 2012 онд 19%-д хүрсэн байна. Харин эдийн засгийн уналтын үеэр 2014 онд эргээд буурсан бол 2015 оноос эхлэн сэргэж 2018 онд 21 хувьд хүрсэн. 2019 оноос буюу Ковид цар тахал эхэлсэн үеэс уналт үзүүлсэн хэдий ч 2021 онд дэлхийн болон дотоодын хөрөнгийн зах зээлийн өсөлтийн үеэр хамгийн өндөр өсөлтийг үзүүлж чадсан байна. **Харин 2023 оны 5 сарын байдлаар 7% гарч байгаа нь өмнөх 16 жилийн дундаж дүнгээс 3%-аар бага үзүүлэлт юм.**

МХБ-ИЙН I АНГИЛЛЫН 26 ХУВЬЦААТ КОМПАНИ 2007-2023M5

Чөлөөт хөрвөх хувьцаа ба нийт арилжигдсан ширхэг, сая ширхгээр




I АНГИЛЛЫН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ДҮН

2023 оны эхний 5 сарын байдлаарх өдрийн дундаж арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн байна.

Хөрвөх чадварыг илтгэдэг бас нэгэн үзүүлэлт нь өдрийн дундаж арилжаа билээ. Энэ үзүүлэлт 2023 оны эхний 5 сарыг 2022 оны 12 сартай харьцуулахад 56.6% өсөж 46.2 сая төгрөгт хүрсэн байна. 5 сард Хаан болон Худалдаа хөгжлийн банкны өдрийн дундаж арилжаа 449.9 болон 242.3 сая төгрөг байсан нь голчлон нөлөөлсөн байна. Мөн нийт арилжааны дундаж дүн 2.2 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 0.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

МХБ-ИЙН I АНГИЛЛЫН 26 ХУВЬЦААТ КОМПАНИ

Өдрийн дундаж арилжааны дүн, сая төгрөгөөр



МХБ-ИЙН I АНГИЛЛЫН 26 ХУВЬЦААТ КОМПАНИ

Нийтарилжааны дүн, тэрбум төгрөгөөр




5-р сард ихэнх хувьцаануудын арилжааны идэвх өмнөх сараас өссөн үзүүлэлттэй байна.

Инвескор ББСБ, АПУ, Талх чихэр, Төрийн банк, Говь, ЛэндМН ББСБ зэрэг компаниудын хувьцаа өмнөх сараас өссөн үзүүлэлттэй гарсан. Харин Богд банк 1.4 тэрбум, Бодь даатгал 507 сая, Ард санхүүгийн нэгдэл 692 сая төгрөгийн арилжаа тус тус хоёр өдөрт хийгдсэнээр 4-р сарын өдрийн дундаж арилжаа өсөхөд голлох нөлөөг үзүүлсэн байна.

МХБ-ИЙН I АНГИЛЛЫН 26 ХУВЬЦААТ КОМПАНИ

Өдрийн дундаж арилжааны дүн, сая төгрөг




Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 26 хувьцаат компанийн өдрийн дундаж арилжаа 2017-2022 оны хооронд 4.4 дахин өссөн байна. 2023 оны эхний 5 сарын байдлаар 46.2 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн юм. Харин 5 сард 38 сая төгрөг гарсан нь өмнөх сараас 55.7% өссөн үзүүлэлт болов.

5-р сард гарсан өсөлтөд Хаан болон Худалдаа хөгжлийн банк олон нийтэд нээлттэй ХК болж IPO хийсэн нь голлох нөлөөг үзүүллээ.

МХБ-ИЙН I АНГИЛЛЫН 26 ХУВЬЦААТ КОМПАНИ

Өдрийн дундаж арилжааны дүн, сая төгрөг



ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Энэ сарын байдлаар Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 26 хувьцаат компаниудын хөрвөх чадвар өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн үзүүлэлттэй гарч байна. Системийн нөлөө бүхий 5 банкний IPO хийгдэж дууссан нь хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвхийг нэмэгдүүллээ. Хаан банкны хувьд 183 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх байснаас 336 тэрбум төгрөг мөн Худалдаа хөгжлийн банк татан төвлөрүүлэх дүнгээс 26.4%-аар давсан буюу 105.5 тэрбум төгрөгийн захиалга тус, тус авсан нь хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон өдрийн дундаж арилжааны дүнг өсгөхөд голлох нөлөөллийг үзүүлсэн юм.

Богд банкны хувьцаа 20 хуваагдаж өдөрт дундаар 930,019 ширхэг хувьцаа арилжаалагдаж байсан нь ханшийн уналтад нөлөөлж байсан бол 5 сард арилжааны идэвх буурч ханш өслөө. Талх чихэр ХК-ийн чөлөөт хөрвөх хувьцааны тоо буурч 169,832 болсноор ханш өсч 37.5 мянгад хүрээд байсан бол 5-р сарын дундуур заралт нэмэгдэж ханш 29.5 мянган төгрөг болсон байна.

Инфляцийн түвшин сүүлийн саруудад алгуур буурч байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөлөл арилж байгааг илтгэж байна. Мөн шатахууны үнийн төсөөлөл буурч байгаа нь инфляцийн төсөөллийг багасгав. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл болон нийлүүлэлт нэмэгдэж байгаа нь валютын ханшийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт болон инфляцийг бууруулахад эерэгээр нөлөөлж байна.



TAVAN BOGD КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

Андеррайтерийн хэлтэс